



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo>
цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад
танилцуулга, мэдээтэй танилцана уу.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

2025 он | №1

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл: 492.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. 2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал өмнөх оны мөн үеэс 1,168.7 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн дүнгээс 1,197.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Төсвийн орлогын хувьд: 2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1,668.2 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 60.2 тэрбум төгрөг буюу 3.5 хувиар дутуу биелсэн бол өмнөх оны мөн үеэс 1,062.3 тэрбум төгрөг буюу 38.9 хувиар буурсан байна.

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө тайлант хугацаанд 96.5 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөснөөс 60.2 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь татварын орлого 9.1 хувь буюу 146.7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс дутуу биелсэнтэй холбоотой байна.
- Тайлант хугацаанд нийгмийн даатгал, гадаад үйл ажиллагаа, тусгай зориулалтын орлого болон онцгой албан татвараас бусад төрлийн татварын орлого 3.4-38.0 хувиар төлөвлөснөөс дутуу биелсэн гүйцэтгэлтэй байна.
- Татварын бус орлогын төлөвлөгөө 2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр 86.5 тэрбум төгрөгөөр давж биелснээр 169.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь хувьцааны ногдол ашига, түрээсийн орлого, навигацын орлого, хөрөнгийн орлого болон бусад орлогоос бусад төрлийн татварын бус орлого төлөвлөснөөс давж биелсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр 2,160.9 тэрбум төгрөгт хүрч 1,257.3 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 63.2 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад 36.8 хувиар дутуу зарцуулагдсан ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.2 хувиар буюу 106.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үеэс 3.5 тэрбум төгрөгөөр буурсан бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 33.6 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарчээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2025 онд нийт 3,124.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. 2025 оны 1 дүгээр сард 100.0 хувийн гүйцэтгэлтэй ба 500.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 492.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр 1,668.2 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2,160.9 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 492.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1,168.7 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн дүнгээс 1,197.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

График 1. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн нийт алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,168.7 тэрбум төгрөгөөр буурсан нь өнгөрсөн оны мөн үеэс нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 1,062.3 тэрбум төгрөгөөр буурч, төсвийн нийт зарлага 106.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээр төсвийн зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 33.7 пунктээр бага гарсантай холбоотой байна.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Тэрбум төгрөгөөр

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	ӨО-ны мөн үед	2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь.	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,138.8	-1,671.5	-283.8	17.0	1,387.7
Засгийн газрын бонд	30.0	0.0	-300.0	0.0	-300.0
Засгийн газрын зээл	-492.8	-18.4	91.1	496.2	109.4
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0	0.0
Өмч хувьчлал	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ДҮН	676.0	-1,689.8	492.7	29.2	1,197.1

Эх сурвалж: Сангийн яам

2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 121.4 тэрбум төгрөг төлсөн бол 30.3 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч, 300.0 тэрбум төгрөгийн гадаад бонд шинээр гаргасан байна.

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

“ Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 1,668.2 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 38.9 хувь буюу 1,062.3 тэрбум төгрөгөөр, орлогын төлөвлөгөө 3.5 хувь буюу 60.2 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл улсын төсөв 8.6 хувь буюу 86.8 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 22.9 хувь буюу 134.7 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 0.2 хувь буюу 0.3 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 1.7 хувь буюу 9.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс тус тус дутуу төвлөрчээ.

” Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 91.9 хувь буюу 97.6 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 30.8 хувь буюу 124.8 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 11.2 хувь буюу 45.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн орлогын 2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Тэрбум төгрөгөөр

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,023.1	942.7	586.8	452.2	539.1	530.0	204.0	203.7
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	11.1	17.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,012.0	925.2	586.8	452.2	539.1	530.0	204.0	203.7
Татварын орлого	775.6	763.7	500.3	365.2	339.4	330.3	204.0	203.7
Орлогын албан татвар	92.2	93.9	440.5	315.7	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	339.4	330.3	204.0	203.7
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	27.6	17.1	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	306.8	296.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	111.4	113.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	2.4	2.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	142.5	143.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	120.2	114.2	32.2	32.3	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	236.4	161.5	86.5	87.0	199.7	199.7	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	74.4	157.7	47.8	49.7	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.7	0.1	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	1.0	3.8	0.9	0.1	199.7	199.7	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	161.0	0.0	37.1	37.1	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

График 2. Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /Хувиар/




Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 87.4 хувийг татварын орлого, 12.6 хувийг татварын бус орлого эзэлж байна.

“
Татварын орлого 1,457.3 тэрбум төгрөг болж, орлогын төлөвлөгөө 9.1 хувь буюу 146.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.
 ”

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 44.0 хувь буюу 1,143.9 тэрбум төгрөгөөр буурсан бол, татварын бус орлого 63.1 хувь буюу 81.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Татварын орлогын 28.1 хувийг орлогын албан татвар, 22.5 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.2 хувийг хөрөнгийн албан татвар, 20.3 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 7.8 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 9.9 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 10.1 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 3. Татварын орлого /Тэрбум төгрөгөөр/



Тайлант хугацаанд татварын орлого төлөвлөснөөс 9.1 хувь буюу 146.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрөхөд нэмэгдсэн өртгийн албан татвар 3.4 хувиар (10.5 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 38.0 хувиар (10.5 тэрбум төгрөг), бусад татвар төлбөр хураамж 3.9 хувиар (5.9 тэрбум төгрөг) тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн нь нөлөөлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2025 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр татварын орлого 44.0 хувь буюу 1,143.9 тэрбум төгрөгөөр буурахад орлогын албан татвар 46.6 хувь (358.0 тэрбум төгрөг)-аар, хөрөнгийн албан татвар 35.0 хувь (9.2 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 33.9 хувь (151.8 тэрбум төгрөг) -аар тус тус буурсан нь нөлөөлжээ.

“


Татварын бус орлого 210.9 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 81.6 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 86.5 тэрбум төгрөг буюу 69.5 хувиар илүү төвлөжээ.

”

Төлөвлөгөөтэй харьцуулахад торгуулийн орлого 16.9 тэрбум төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 8.4 тэрбум төгрөгөөр, хүүгийн орлого 14.1 тэрбум төгрөгөөр, газрын тосны орлого 53.9 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ.

Харин навигацийн орлого 1.7 тэрбум төгрөг, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 0.6 тэрбум төгрөгөөр, бусад орлого 6.3 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

График 4. Татварын бус орлогын бүтэц /Хувиар/



Татварын бус орлогын 98.2 хувийг нийтлэг татварын бус орлого, 1.6 хувийг тусламжийн орлого, 0.05 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна.

Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 12.1 хувийг хүүгийн орлого, 15.7 хувийг торгуулийн орлого, 40.0 хувийг газрын тосны орлого, 25.3 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 0.1 хувийг түрээсийн орлого, 2.4 хувийг навигацийн орлого эзэлсэн бол 4.4 хувийг бусад орлого бүрдүүлж байна.



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 106.4 тэрбум төгрөг буюу 5.2 хувиар нэмэгдэж 2,160.9 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.



3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 3,418.2 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 63.2 хувийг зарлагдаж 1,257.3 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 106.4 тэрбум төгрөг буюу 5.2 хувиар нэмэгдэж 2,160.9 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн зарлагын 2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэл /төсвийн шатлалаар/

Тэрбум төгрөгөөр

Зардлын зүйл	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,934.4	1,316.1	1,258.5	528.5	502.4	482.7	336.3	276.4
НИЙТ ЗАРЛАГА	1,921.5	1,364.4	1,180.1	474.1	502.4	482.7	336.3	276.5
УРСГАЛ ЗАРДАЛ	1,841.5	1,361.0	532.5	181.2	502.4	482.7	336.3	276.5
Бараа, ажил, үйлчилгээний зардал	781.8	547.9	281.1	123.7	0.1	0.0	1.4	0.7
Зээлийн үйлчилгээний төлбөр	229.9	199.0	21.4	18.6	0.0	0.0	0.0	0.0
Татаас	314.4	202.7	39.7	34.0	0.0	0.0	0.0	0.0
Урсгал шилжүүлэг	515.3	411.3	190.2	4.9	502.3	482.7	334.9	275.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	80.0	3.3	647.7	292.9	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	13.0	-48.2	78.4	54.4	0.0	-0.1	0.0	-0.1
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-922.5	-390.9	-671.7	-76.3	36.7	47.3	-132.3	-72.8

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 618.3 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 730.0 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 19.7 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 59.9 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 5.2 хувь буюу 106.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд хөрөнгийн зардал 162.6 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал зардал 268.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.



Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 17.5 хувь буюу 207.0 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулсан гүйцэтгэлтэй байна.



Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл /зардлын эдийн засгийн ангиллаар/

Тэрбум төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	ӨО-ны мөн үе	2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,054.5	3,418.2	2,160.9	63.2	-1,257.3
НИЙТ ЗАРЛАГА	2,049.4	3,326.9	2,154.9	64.8	-1,172.0
УРСГАЛ ЗАРДАЛ	1,590.5	2,599.2	1,858.6	71.5	-740.6
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	506.4	1,009.7	627.2	62.1	-382.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348.9	540.6	474.3	87.7	-66.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41.1	79.1	47.7	60.2	-31.5
Хангамж, бараа материалын зардал	8.9	32.7	8.0	24.3	-24.8
Нормативт зардал	14.2	44.8	19.3	43.0	-25.5
Эд хогшил, урсгал засварын зардал	2.0	21.5	1.9	9.0	-19.6
Томилолт, зочны зардал	2.4	12.9	3.5	27.3	-9.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44.3	150.7	28.9	19.2	-121.8
Бараа үйлчилгээний бусад зардал	44.4	127.3	43.6	34.3	-83.7
ХҮҮ	221.2	251.3	217.7	86.6	-33.6
ТАТААС	23.9	154.5	37.0	24.0	-117.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	839.0	1,183.7	976.7	82.5	-207.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	211.6	376.5	288.2	76.5	-88.3
Бусад урсгал шилжүүлэг	627.4	807.3	688.6	85.3	-118.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	458.9	727.7	296.3	40.7	-431.4
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5.1	91.4	6.0	6.6	-85.4

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 86.0 хувь буюу 1,858.6 тэрбум төгрөг нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 52.6 хувийг урсгал шилжүүлэг, 33.7 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 11.7 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 2.0 хувийг татаас тус тус эзэлж байна.




График 5. Урсгал зардлын бүтэц /Хувиар/

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар 39 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд 2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр улсын төсвийн нийт зарлага 618.3 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж 68.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлагын 24.9 хувийг Сангийн сайдын багц, 20.7 хувийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц, 29.5 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 0.9 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 8.3 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, үлдэх 15.7 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын зардал эзэлж байна.

Хүснэгт 6. Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Сая төгрөгөөр

Төсвийн ерөнхийлөн захирагч	2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэл			
	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	3,040.8	1,101.1	1,939.7	36.2
Монгол Улсын Их Хурлын дарга	13,616.1	6,387.3	7,228.8	46.9
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	432.5	387.3	45.2	89.5
Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	2,105.7	1,262.9	842.8	60.0
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	18,327.7	12,293.6	6,034.1	67.1
Улсын ерөнхий прокурор	10,858.3	7,795.9	3,062.4	71.8
Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	2,676.0	2,035.3	640.8	76.1
Монгол Улсын Ерөнхий сайд	87,307.3	18,339.0	68,968.3	21.0
Монгол Улсын Шадар сайд /онцгой байдлын асуудал эрхэлсэн/	23,321.8	17,843.1	5,478.7	76.5
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	10,478.1	3,412.4	7,065.7	32.6
Сангийн сайд	347,942.8	219,358.9	128,583.9	63.0
Хууль зүй, дотоод хэргийн сайд	129,876.6	87,327.7	42,548.9	67.2
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	11,063.2	8,942.5	2,120.6	80.8
Батлан хамгаалахын сайд	56,001.7	38,281.1	17,720.6	68.4
Боловсролын сайд	321,049.2	270,730.2	50,319.1	84.3
Гадаад харилцааны сайд	27,445.7	2,443.0	25,002.7	8.9
Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	2,318.6	1,059.9	1,258.8	45.7
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	125,029.3	5,077.7	119,951.6	4.1
Эрүүл мэндийн сайд	183,493.9	168,643.1	14,850.8	91.9
Төрийн албаны зөвлөлийн дарга	1,047.0	437.3	609.6	41.8
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	8,347.0	269.4	8,077.6	3.2
Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга	951.1	609.9	341.2	64.1
Монгол Улсын Ерөнхий аудитор	4,032.5	2,945.8	1,086.7	73.1
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1,500.0	984.7	515.4	65.6
Үндэсний статистикийн хорооны дарга	2,265.1	1,485.0	780.1	65.6
Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга	409.0	329.7	79.4	80.6
Зам, тээврийн сайд	16,523.7	1,029.8	15,494.0	6.2
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	10,315.5	358.6	9,956.9	3.5
Эрчим хүчний сайд	12,299.0	274.6	12,024.4	2.2
Авлигатай тэмцэх газрын дарга	6,871.5	3,698.7	3,172.8	53.8
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	33,107.7	18,505.5	14,602.3	55.9
Монгол Улсын Шадар сайд /өрсөлдөөний асуудал эрхэлсэн/	1,110.0	314.4	795.6	28.3
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	444,319.3	403,244.7	41,074.6	90.8
Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга	1,495.2	661.4	833.8	44.2
Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга	422.3	156.7	265.6	37.1
Шүүхийн сахилгын хорооны дарга	431.7	360.0	71.7	83.4
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд, Эдийн засаг, хөгжлийн сайд	6,900.2	5,239.5	1,660.6	75.9
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	5,152.7	2,208.6	2,944.2	42.9
Монгол Улсын сайд, боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга	539.8	283.6	256.2	52.5
НИЙТ ЗАРДАЛ	1,934,425.8	1,316,119.6	618,306.2	68.0

Эх сурвалж: Сангийн яам

2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр 500.0 сая төгрөгийг зарцуулж 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2025 онд нийт 3,124.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. 2025 оны 1 дүгээр сард 100.0 хувийн гүйцэтгэлтэй ба 500.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.


Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл Сая төгрөгөөр

Хуулийн дугаар	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	2025 оны төсөв	2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэл			
			Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
I	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ	1,000.0	0.0	0.0	0.0	-
II	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	8,560.0	0.0	0.0	0.0	-
III	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	1,545.5	0.0	0.0	0.0	-
IV	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	51,444.9	0.0	0.0	0.0	-
V	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	42,477.6	0.0	0.0	0.0	-
VI	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	24,230.6	0.0	0.0	0.0	-
VII	МОНГОЛ УЛСЫН САЙД, 20 МИНУТЫН ХОТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	15,671.5	0.0	0.0	0.0	-
VIII	МОНГОЛ УЛСЫН САЙД, БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	8,098.5	0.0	0.0	0.0	-
IX	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	11,250.4	0.0	0.0	0.0	-
X	САНГИЙН САЙД	126,249.3	500.0	500.0	0.0	100.0
XI	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	108,551.9	0.0	0.0	0.0	-
XII	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	75,403.9	0.0	0.0	0.0	-
XIII	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	80,829.8	0.0	0.0	0.0	-
XIV	БОЛОВСРОЛЫН САЙД	472,677.8	0.0	0.0	0.0	-
XV	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	52,242.3	0.0	0.0	0.0	-
XVI	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	951,219.0	0.0	0.0	0.0	-
XVII	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	145,245.7	0.0	0.0	0.0	-
XVIII	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	354,097.3	0.0	0.0	0.0	-
XIX	ХҮҮС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	58,580.5	0.0	0.0	0.0	-
XX	ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	35,745.1	0.0	0.0	0.0	-
XXI	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	196,193.2	0.0	0.0	0.0	-
XXII	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	193,095.6	0.0	0.0	0.0	-
XXIII	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	2,360.9	0.0	0.0	0.0	-
XXIV	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	4,628.2	0.0	0.0	0.0	-
XXV	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	62,984.5	0.0	0.0	0.0	-
XXVI	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	29,849.1	0.0	0.0	0.0	-
XXVII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1,178.8	0.0	0.0	0.0	-
XXVIII	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	250.0	0.0	0.0	0.0	-
XXIX	ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА	300.0	0.0	0.0	0.0	-
XXX	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	2,712.0	0.0	0.0	0.0	-
XXXI	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	2,000.0	0.0	0.0	0.0	-
XXXII	МОНГОЛ УЛСЫН САЙД, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	2,408.1	0.0	0.0	0.0	-
XXXIII	АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД	984.0	0.0	0.0	0.0	-
НИЙТ		3,124,066.0	500.0	500.0	0.0	100.0


Эх сурвалж: Сангийн яам

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

/Тэрбум төгрөгөөр/



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН




↑ -Өөрчлөлт (Өнгөрсөн оны мөн үеэс)

Нийгмийн даатгалын сангийн зарлагад 482.7 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 114.1 тэрбум төгрөг буюу 31.0 хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэврийн даатгалын сангийн зарлага 86.9 тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 10.5 тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ий даатгалын сангийн зарлага 0.4 тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 10.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр нийгмийн даатгалын санд нийт 530.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 1.7 хувь буюу 9.1 тэрбум төгрөгөөр дутуу биелэж орлогын гүйцэтгэл 7.7 хувьтай гарсан байна.


График 6. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын бүтэц /Хувиар/



6. Эрүүл мэндийн даатгалын сан

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 0.2 хувиар дутуу биелжээ.


График 7. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /Тэрбум төгрөгөөр/



Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр 203.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөснөөс 0.2 хувь буюу 0.3 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 276.4 тэрбум төгрөгийн зарлага хийгдэж өнгөрсөн оны мөн үеэс 72.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

График 8. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /Тэрбум төгрөгөөр/



2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 336.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, 276.4 тэрбум төгрөгийг зарцуулж, тус сангийн гүйцэтгэл 82.2 хувьтай гарчээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тус сангийн нийт зарлага 72.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 730.0 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

7. Орон нутгийн төсөв

2025 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 452.2 тэрбум төгрөг болж төлөвлөсөн дүнгээс 22.9 хувь буюу 134.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрч, орон нутгийн төсвийн нийт зарлага 528.5 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 58.0 хувь буюу 730.0 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсанаар орон нутгийн төсвийн тэнцэл 76.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 11.2 хувь буюу 45.5 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн нийт зарлага 3.5 дахин буюу 412.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 91.8 хувийг орон нутгийн төсвийн орлого, 8.2 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 37.1 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөгдөж 100 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт 8. Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

Сая төгрөгөөр

АЙМАГ	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	3,871.9	3,871.9	100.0	-	-	-
Баян-Өлгий	2,471.6	2,471.6	100.0	-	-	-
Баянхонгор	3,147.1	3,147.1	100.0	-	-	-
Булган	1,491.3	1,491.3	100.0	-	-	-
Говь-Алтай	2,473.8	2,473.8	100.0	-	-	-
Дорноговь	0.0	0.0	0.0	-	-	-
Дорнод	0.0	0.0	0.0	-	-	-
Дундговь	1,609.1	1,609.1	100.0	-	-	-
Завхан	3,973.7	3,973.7	100.0	-	-	-
Өвөрхангай	3,030.2	3,030.2	100.0	-	-	-
Өмнөговь	0.0	0.0	0.0	-	-	-
Сүхбаатар	1,868.1	1,868.1	100.0	-	-	-
Сэлэнгэ	0.0	0.0	0.0	-	-	-
Төв	179.5	179.5	100.0	-	-	-
Увс	3,297.8	3,297.8	100.0	-	-	-
Ховд	1,170.1	1,170.1	100.0	-	-	-
Хөвсгөл	4,347.8	4,347.8	100.0	-	-	-
Хэнтий	3,404.1	3,404.1	100.0	-	-	-
Дархан-Уул	0.0	0.0	0.0	-	-	-
Улаанбаатар	0.0	0.0	0.0	-	-	-
Орхон	0.0	0.0	0.0	-	-	-
Говьсүмбэр	773.5	773.5	100.0	-	-	-
ДҮН	37,109.5	37,109.5	100.0	-	-	-

Орон нутгийн нийт орлого төлөвлөснөөс 134.7 тэрбум төгрөг буюу 22.9 хувиар дутуу төвлөрсөн нь орон нутгийн орлого 24.5 хувь буюу 134.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөнтэй шууд холбоотой байна.

График 9. Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



Орон нутгийн орлогыг аймгуудаар харуулбал: Архангай аймаг 2,461.6 сая, Баян-Өлгий аймаг 2,984.5 сая, Баянхонгор аймаг 261.5 сая, Говь-Алтай аймаг 351.1 сая, Дорноговь аймаг 2,020.9 сая, Дорнод аймаг 2,390.9 сая, Дундговь аймаг 1,467.3 сая, Завхан аймаг 89.0 сая, Өвөрхангай аймаг 21.2 сая, Өмнөговь аймаг 69,272.4 сая, Сэлэнгэ аймаг 335.4 сая, Увс аймаг 645.3 сая, Улаанбаатар хот 54,601.6 сая, Орхон аймаг 3,309.0 сая, төгрөгөөр төлөвлөгөөг дутуу биелүүлсэн бол Булган аймаг 169.2 сая, Сүхбаатар аймаг 1,222.3 сая, Төв аймаг 1,507.1 сая, Ховд аймаг 956.4 сая, Хөвсгөл аймаг 261.0 сая, Хэнтий аймаг 860.0 сая, Дархан-Уул аймаг 277.7 сая, Говьсүмбэр аймаг 307.8 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс илүү төвлөрүүлсэн байна.